



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

14251 Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг Чингисийн өргөн чөлөө 11,

Утас 6226-3168 Факс 1976-11) 31-23-15.

E-mail: info@mtd.gov.mn, http://www.mtd.gov.mn


2018-06-29 № 01/31502

тэнгэй 2018-05-29-ны № 29

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ж.ГАНБААТАР, Ш.РАДНААСЭД  
ТАНАА

Монгол Улсын Их Хурлын Эрхэм гишүүд Та бүхнээс агаарын тээврийн салбарын талаар болон бусад холбогдох зарим асуудлаар ирүүлсэн асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна.


Хавсралт: 12 хуудастай.



САЙД

Ж.БАТ-ЭРДЭНЭ

080780



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ж.ГАНБААТАР,  
Ш.РАДНААСЭД НАРЫН АСУУЛГЫН ХАРИУ

**Асуулт 1. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, иргэдийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн агаарын тээврийг хөгжүүлэх, өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр Засгийн газрын зүгээс өнгөрсөн хугацаанд ямар арга хэмжээ авч, тодорхой үр дүнд хүрсэн эсэх.**

Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрхийн 2 жил орчмын хугацаанд олон улсын агаарын тээврийг хөгжүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж байна. Үүнд:

- Бүгд Найрамдах Мальта Улс, БНЧУ, Люсембургийн Их Гүнт Улсын Засгийн газартай Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулж, эдгээр хэлэлцээрийг Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, Засгийн газрын 83, 84, 85 дугаар тогтоолоор батласан;

- Камбожийн Вант Улс, Мьянмарын Холбооны Улсын Засгийн газартай Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулж, Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 151, 152 дугаар тогтоолоор баталсан. Монгол Улс дээрх хэлэлцээрүүдийг хүчин төгөлдөр болгох дотоодын журмаа гүйцээсэн талаар холбогдох талуудад дипломат шугамаар мэдэгдэж, Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-д бүртгүүлэх ажлыг хийж байна. Эдгээр улс орнуудтай агаарын харилцаа тогтоож, агаарын тээвэрлэлт хийх эрх зүйн зохицуулалт бүрдсэн.

- Шинээр нэмэгдсэн нислэгийн чиглэлийн тухайд, "МИАТ" ТӨХК нь 2017 оны 05 дугаар сараас Улаанбаатар-Бусаны чиглэлд долоо хоногт 2 удаа, 2017 оны 11 дүгээр сараас Улаанбаатар-Бангкок чиглэлд долоо хоногийн 2 удаагийн давтамжтай хуваарьт нислэг, мөн оны 7 дугаар сараас Сидней, Брисбан, Мельбурн, Перт, Дели, Бангкок хотууд руу аялалын дугаар хамтран ашиглах зарчмаар нислэг гүйцэтгэж байна. "Хүннү Эйр" ХХК нь 2016 оны 8 дугаар сараас Бугатын чиглэлд, 2017 оны 06 дугаар сараас Улаан-Үүд хотын чиглэлд тус тус хуваарьт нислэг гүйцэтгэж байна.

- Гадаад улс руу чиглэсэн нислэгийн чиглэлийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд "МИАТ" ТӨХК -ийг 2016 оны 8 дугаар сараас Улаанбаатар-Дели чиглэлд, 2017 оны 9 дүгээр сард Бангкок, Сингапурын талтай аялалын дугаар хуваан ашиглах маркетингийн агаарын тээвэрлэгчээр, "Аэромонголиа" ХХК-ийг 2016 оны 7 дугаар сард Улаанбаатар - Новосибирск, "Хүннү Эйр" ХХК-ийг Ховд-Усть Каменегорск чиглэлд тус тус нислэг гүйцэтгэх агаарын тээвэрлэгчээр томиллоо.

Агаарын тээврийн салбарын зарим үзүүлэлтийн тухайд, олон улсын агаарын тээврээр 2017 онд 926 738 зорчигч тээвэрлэсэн нь 2016 оныхоос (790 459 зорчигч) 17 хувиар өсчээ. Орон нутгийн агаарын тээврийн тухайд, 2016 онд нийт 232,5 мянга, 2017 онд 325,0 мянган зорчигч тээвэрлэсэн. Үүнээс орон нутгийн 9 чиглэлд хуваарьт нислэг

гүйцэтгэж, 2016 онд 105,0 мянга, 2017 онд 117,7 мянган зорчигч тус тус тээвэрлэсэн. Орон нутгийн нислэгийн ихэнхийг уул уурхайн нислэг эзлэж байна.

Хил орчмын нислэгийн сүлжээ өргөжихөд тодорхой дэвшил гарч, 2016 оноос хойш шинээр Улаан-Үүд, Бугатын чиглэлд нислэг гүйцэтгэж эхэлсэн. Мөн Хятадын талаас шинээр нислэг гүйцэтгэхэд гадаад, дотоодын тээвэрлэгч гэж ялгаваргүйгээр олгодог татаасын бодлогын дэмжлэгтэйгээр Чойбалсангийн нисэх буудлаас Хайлаар, Манжуур, Бугатын чиглэлийн нислэг тогтворжсон. Хайлаар, Манжуур, Бугатын чиглэлийн зорчигч тээвэрлэлт 2017 онд 2016 оныхоос 2 дахин, Эрээний чиглэлийн зорчигч тээвэрлэлт 11 дахин өсчээ.

**Асуулт 2. Ижил зайд нислэг үйлдэж байгаа жишиг үнэ тарифыг Монгол улсын иргэдэд санал болгохгүй байгаа "Корэйн Эйр" компанийн үйлдэл нь Агаарын харилцааны олон улсын хууль тогтоомж, гэрээг зөрчиж байгаа эсэх.**

Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын DOC 9626 "Олон улсын агаарын тээврийн зохицуулалтын гарын авлага" баримт бичигт олон улсын агаарын тээврийн тарифын зохицуулалтыг үндэсний агаарын тээвэрлэгчийг тухайн нислэгийн зах зээлд шударга, ижил тэгш өрсөлдөх боломж бүрдүүлэх, олон улсын худалдаа, аялал жуулчлалд дэмжлэг үзүүлэх, өрсөлдөөнийг дэмжих зорилгоор агаарын тээвэрлэгчийн уян хатан тариф мөрдөх боломж олгох, мөн үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байх гэсэн үндсэн шалгуурыг харгалзан тогтоож, мөрдөхийг зөвлөмж болгодог. Мөн үйл ажиллагааны цар хүрээ, нөхцөл, цагийн хуваарь болон нислэгийн давтамж, тухайн зах зээлд нэвтрэх боломж, нийгмийн үйлчилгээ үзүүлж байгаа эсэх, үйлчилгээний чанарын түвшин, агаарын тээвэрлэгчийн хүчин чадлаас шалтгаалж үнэ тариф ялгаатай бөгөөд тарифыг тогтооход харгалзан үзэх хүчин зүйл гэж тооцдог байна.

Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хооронд 1991 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан "Хоёр орны нутаг дэвсгэрт болон тэдгээрийн хилийн чанадад агаарын харилцаа тогтоох тухай" хэлэлцээрийн 10 дугаар зүйл (Тариф)-ийн 1 дэх хэсэгт "Аливаа тохиролцсон үйлчилгээнд мөрдөх тарифыг үйлчилгээний зардал, ашиг орлого, түүнчлэн түргэн шуурхай байдал, зочид буудлаар хангах зэрэг үйлчилгээтэй холбоотой зүйл, тогтоосон маршрутын аливаа хэсэгт агаарын тээврийн бусад байгууллагын мөрддөг тариф зэрэг холбогдох бүх зүйлийг харгалзан үзсэний үндсэн дээр зүй зохистой түвшинд тогтооно" гэж заасан.

Олон улсын агаарын тээврийн жишиг тарифыг тухайн нислэгийн зай, зах зээлд нөлөөлж буй хүчин зүйлийг харгалзан Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбоо IATA-оос харьцангуй өндөр түвшинд тогтоодог. Дээрх хэлэлцээрийн хүрээнд "МИАТ" ТӨХК болон "Корэян Эйр" компаниуд Улаанбаатар-Сөүлийн чиглэлд нислэгийн тарифыг ойролцоо түвшинд, хоёр орны зах зээлийн нөхцөл, онцлогийг харгалзан тогтоосон тариф гэж үзэж байна.

Агаарын тээврийн тарифт нөлөөлж буй үндсэн хүчин зүйл нь агаарын хөлгийн шатахууны үнэ юм. Агаарын хөлгийн шатахууны үнэ 6 дугаар сарын дунджаар 1 тонн нь "Чингис хаан" нисэх буудал дээр 972 ам.доллар, Сөүлд 802 ам.доллар, Бусанд 836 ам.доллар, Бээжинд 840 ам.доллар, Хонг Конгт 727 ам.доллар, Москвад ам.долларын үнэтэй байна. 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар далавчинд сумлах үнэ нь 972 ам.доллар байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад (733 ам.доллар байсан)

32 хувиар өссөн үзүүлэлттэй, “Чингис хаан” олон улсын нисэх буудал дээр сумлаж буй шатахууны үнэ нь дээрх улсын нисэх буудлын үнээс дунджаар 28 хувиар өндөр байна.

“Корэйн Эйр” компанийн Улаанбаатар-Сөүлийн чиглэлтэй ойролцоо зайд үйлдэж буй бусад чиглэлийн нислэгийн тарифын судалгааг хавсаргав.

**Асуулт 3. “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд 1991 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан хэлэлцээр”-ийг эргэн харах, засаж сайжруулах шаардлагатай эсэх.**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хооронд “Хоёр орны нутаг дэвсгэрт болон тэдгээрийн хилийн чанадад агаарын харилцаа тогтоох тухай” 1991 онд байгуулсан хэлэлцээрийн дагуу хоёр орны хоорондын агаарын тээврийн зах зээлд бий болсон өнөөгийн тогтолцоог халж, ижил тэгш, шударга өрсөлдөөний зарчмаар үйл ажиллагаа явуулах зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байгаа.

Хоёр талын Иргэний нисэхийн удирдах байгууллагууд хоорондын 1998 онд хийсэн хэлэлцээгээр 7 хоногт 500 зорчигчийн суудлын багтаамжийн хүрээнд 3 давтамжтай нислэг гүйцэтгэхээр тохирч, улмаар 2001 онд хоёр талын аяллын дугаар хуваан ашиглах зохицуулалт болон багтаамжийг 5 давтамжтай 800 зорчигчийн суудал байхаар нэмэгдүүлсэн. Хоёр тал 2003 онд хийсэн уулзалтаар суудлын хязгаарлалтыг халж, 6 давтамжтай нислэг гүйцэтгэхээр тохирч, өнөөдрийг хүртэл энэ тохиролцоогоор буюу хоёр талын агаарын тээвэрлэгчид 7 хоногт тус бүр 6 удаагийн давтамжтай нислэг гүйцэтгэж байна. Зөвхөн нислэгийн давтамжаар тохирсон нь 2004-2013 онд Солонгосын тал 296, Монголын тал хамгийн ихдээ 189 суудалтай агаарын хөлгөөр нислэг гүйцэтгэж байснаас суудлын зөрүүнээс шалтгаалж Монголын талд илт хохиролтой, тэнцвэргүй байдал бий болгосон.

“МИАТ” ТӨХК нь агаарын хөлгийн парк шинэчлэл хийсэн хэдий ч өнөөдрийн байдлаар 258 хүртэлх зорчигчдын багтаамжтай агаарын хөлгөөр нислэг гүйцэтгэж байгаа нь “Корейн Эйр” компанид давуу байдал үүсгэсэн хэвээр байна. Зорчигч тээврийн эрэлт хэрэгцээ, зорчигч урсгалыг харгалзан зуны оргил ачааллын үеэр хоёр талын агаарын тээвэрлэгчид долоо хоногийн 5 хүртэл удаагийн /үндсэн 6 давтамжаас илүүгүй байх зарчмаар/ нэмэлт нислэг гүйцэтгэж байгаа ч улирлын чанартай өсдөг зорчигчийн урсгалын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Монголын тал суудлын зөрүүтэй байдлыг арилгаж, зах зээлд нийлүүлэх зорчигчийн суудлын тоог ижил хэмжээнд тогтоохыг эрмэлзэж, ижил тэгш багтаамжтай тээвэрлэлт хийх зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор нислэгийн давтамж нэмэгдүүлэх, суудлын тоог тохирох талаар 2003 оноос хойш 12 удаагийн уулзалт, хэлэлцээ хийсэн боловч тохиролцоонд хүрээгүй болно.

Олон улсын нисэх буудал ашиглалтад орсноор багтаамж томтой агаарын хөлөг хүлээн авах дэд бүтэц, техникийн боломж бүрдэж, Солонгосын талтай тохирсон нислэгийн давтамжийн хүрээнд багтаамжийн зөрүүтэй байдал улам бүр нэмэгдэхээр байна.

Иймд "Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-д холбогдох өөрчлөлт оруулж, бодлогын шийдвэр гарсны дараа Солонгосын талтай агаарын харилцааны асуудлаар хэлэлцээ хийж, ижил тэгш нөхцөлөөр зах зээлийг өргөжүүлэх, хүртээмжтэй агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх зохицуулалтыг бүрдүүлж, тодорхой хэмжээнд агаарын харилцааны либералчлалыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Асуудлыг шийдвэрлэх арга зам нь өнөөдрийн байгаа 6 удаагийн нислэгийн давтамжийг агаарын хөлгийн хүчин чадал, зах зээлийн суудлын багтаамжтай уялдуулан тогтоох замаар хэрэгжүүлэхээр байна.

***Асуулт 4. "МИАТ" ХК болон "Корейн Эйр" компанийн хооронд 2012 онд 18 жилийн хугацаатай байгуулсан гэх хамтран ажиллах санамж бичгийг хүчингүй болгосон тохиолдолд эрх зүйн болон эдийн засгийн ноцтой хохирол Монгол Улсын талд үүсэх эсэх.***

"МИАТ" ХК болон "Корейн Эйр" компанийн хооронд 2012 оны 03 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичигт талууд аюулгүй ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах тал дээр хамтран ажиллах хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх, зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах үүргээ хамтын ажиллагаа болон өрсөлдөөний зарчмаар хослуулан явуулах, аялалын дугаар хуваан гэрээний дагуу үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулах зэрэг чиглэлээр хамтран ажиллахаар, тодорхой хугацаагүйгээр байгуулжээ.

Мөн "МИАТ" ХК-ийн үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэх, "SKYTEAM" агаарын тээвэрлэгчдийн нэгдэлд элсэхэд тавигддаг шаардлагад нийцүүлэхэд идэвх зүтгэл гарган ажиллах зэрэг "МИАТ" ХК-ийн үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах талаарх хамтын ажиллагааны чиглэлийг тогтоож аливаа санхүү, эдийн засгийн үүрэг хүлээгээгүй тул тус компанийн үйл ажиллагаанд хохирол учруулахааргүй, ямар нэгэн сөрөг үр дагавар байхгүй гэж үзэж байна.

Уг Харилцан ойлголцлын санамж бичиг нь талууд мэдэгдэл өгснөөр хүчингүй болохоор байна. Харилцан ойлголцлын санамж бичгийг хүчингүй болгох шаардлага бий болоогүй, мөн хүчингүй болгосноор Монголын талд ноцтой хохирол үүсэхээргүй байна. /Харилцан ойлголцлын санамж бичгийг албан бус орчуулгын хамт хавсаргав./

***Асуулт 5. "МИАТ" ХК-ийн хувьцааг Хөрөнгийн биржээр дамжуулан хувьчлах асуудлыг хэдий хугацаанд зохион байгуулах, хувьцааны тодорхой хувийг төрийн мэдэлд үлдээх эсэх.***

Улсын Их Хурлын "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай" 2001 оны 10 дугаар тогтоолд "... Монголын иргэний агаарын тээвэр ТӨҮГ-ыг салбаруудын нь хамт нэг багц болгох, хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулах нөхцөлтэйгээр олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий гадаадын авиакомпанид уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах чиглэлийг баримтлах"-аар заасан. Үндсэндээ 2001-2004, 2005-2008 онд төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл, шийдвэрүүдэд "МИАТ" ХК-ийн бизнесийн болон нийгмийн үйлчилгээний чиглэлийг салгах үйл ажиллагааг хэрэгжүүлсний үндсэн дээр тус компанийг олон улсын гэрээ хэлэлцээр, хууль тогтоомжид нийцүүлэн уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах чиглэлийг тодорхойлж байжээ.

Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрээр олон улсын нислэгт томилогдох агаарын тээврийн компанийн өмчийн эзэмшилд болон аюулгүй ажиллагаанд Засгийн газраас тавих үр нөлөөтэй хяналтын тогтолцоо, хүлээх хариуцлагын шаардлагыг тогтоодог тул 51-ээс доошгүй хувь нь монголын талын өмч байх шаардлагатай, мөн цөөн тооны чиглэлд нислэг гүйцэтгэдэг агаарын тээврийн компанийн хувьчлалд олон улсын томоохон компаниудын оролцох сонирхол төдийлөн байдаггүй тул тухайн зорилт хэрэгжээгүй байна.

Тус компанийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, менежмент, санхүүгийн чадварыг сайжруулах, агаарын хөлгийн парк шинэчлэлтийг хэрэгжүүлэх, олон улсын агаарын тээвэрлэлтийг өргөжүүлэх зорилгоор Улсын Их Хурал, Засгийн газраас компанийн тодорхой хувийг хувьчлах талаар удаа дараа шийдвэр гаргаж байсан хэдий ч өнөөг хүртэл хэрэгжээгүй.

"МИАТ" ХК нь төрийн өмчит үйлдвэрийн газрын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байгаад 2001 оны үнэлгээгээр 5,577 283,2 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байсан бөгөөд нэрлэсэн үнэ нь 100 төгрөгийн 55 772 830 ширхэг хувьцаа бүхий хувьцаат компани болж зохион байгуулагдсан.

Засгийн газраас шууд хөрөнгө оруулалт хийх санхүүгийн эх үүсвэр байхгүй, мөн дэлхийн улс орнуудын жишгээр агаарын тээврийн компанийн ашигт ажиллагааг дээшлүүлэх зорилгоор компанийн өмчлөлийн бүтцийг өөрчлөх замаар хөрөнгө оруулалт хийх боломж бүрдүүлж, оруулсан хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах баталгааг бий болгож, зах зээлд өрсөлдөх нөхцөл боломжийг бүрдүүлэхэд хувьчлалын зорилго оршиж байна.

Засгийн газрын хувьд хувийн хэвшилд суурилсан зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих бодлого баримталж, үйлдвэрлэл, үйлчилгээний салбар дахь төрийн оролцоог бууруулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрийн өмчит зарим хуулийн этгээдийг хөрөнгийн биржээр болон нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчлах, хувьчлалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод, нээлттэй зохион байгуулах зарчмыг баримтлаж байна.

"МИАТ" ТӨХК-ийн өмчийн эзэмшилд олон нийтийн оролцоог хангах, компанийн засаглалыг сайжруулах, үнэ цэнийг өсгөх, техник технологийг шинэчлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор төрийн эзэмшлийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, үлдсэн хувьтай тэнцэх хэмжээний хувьцааг Монголын хөрөнгийн биржээр арилжаалахаар төлөвлөсөн.

"МИАТ" ТӨХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааны хувь хэмжээг бууруулж, хувьчилснаар компанийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналт бий болох, үйлчилгээний чанар, өрсөлдөх чадварыг сайжруулах, үйл ажиллагааг өргөжүүлж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах зэрэг компанийн засаглалын болон санхүү, эдийн засгийн эерэг өөрчлөлт бий болно гэж үзэж байна.

Иймд "МИАТ" ТӨХК-ийн төрийн мэдлийн хувьцааны 49 хүртэлх хувийг хувьчлах урьдчилсан бэлтгэл ажлыг 2018 оноос эхлүүлэх шаардлагатай гэж үзэж, төрийн эзэмшлийн хувьцаанаас нээлттэй худалдах асуудлыг шийдвэрлүүлэхээр Улсын Их Хурлын тогтоолын төсөлд санал оруулсан болно.

**Асуулт 6. Улаанбаатар хотоос алслагдсан аймгуудын ард иргэдэд иргэний агаарын тээврийн үйлчилгээг ойртуулах тогтмолжуулах үнэ тарифыг хямдруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон цаашид баримтлах бодлого**

“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын баримт бичгийн 1.2.12-т “дотоодын агаарын тээврийн үйлчилгээг алслагдсан бүс, орон нутгийн иргэдэд хүргэхэд чиглүүлэх”, 3.14-т “Төрөөс алслагдсан бүс нутагт агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэх “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу орон нутгийн алслагдсан бүс нутгийн иргэдэд агаарын тээврийн үйлчилгээг тэнцвэртэй хүргэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх, дотоодын агаарын тээвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, алслагдсан бүс нутгийн агаарын тээврийн үйлчилгээг тогтмолжуулахад чиглэсэн хөтөлбөрийн төслийг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн нийтлэг журам”-ын дагуу боловсруулж байна.

Орон нутгийн нислэгийн зах зээл жилээс жилд хумигдаж, 2013 онд орон нутгийн 12 чиглэлд хуваарьт нислэг гүйцэтгэж байсан бол 2017 онд 6 чиглэлд хуваарьт нислэг гүйцэтгэж, 3 чиглэлд /Алтай, Баянхонгор, Мөрөн/ татаастай нислэг гүйцэтгэж байна.

Энэ нь орон нутгийн хуваарьт нислэг гүйцэтгэж буй хувийн хэвшлийн агаарын тээвэрлэгчид агаарын хөлгийн парк шинэчлэлт хийх хөрөнгийн эх үүсвэр хомс, орон нутагт шатахуун тээвэрлэснээр үнэ нь өсдөг, мөн авто зам сайжирч, хот хоорондын авто тээврийн сүлжээ өргөжсөнтэй холбоотой агаарын тээврийн зорчигч буурч буй зэрэг хүчин зүйлээс шалтгаалж байна.

Алслагдсан аймаг, сум, суурин газрын иргэдэд агаарын тээврийн үйлчилгээг хүргэх чиглэлээр дээр дурьдсан бодлогын хүрээнд орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ үзүүлэгч агаарын тээвэрлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар 2013 оноос хойш Тосонцэнгэл, Алтай, Мөрөн, Баянхонгор, Баруун-Урт, Ховдын Булган, Үенч сумын чиглэлд 258 удаагийн нислэгээр 10415 иргэдэд үйлчилгээ үзүүлж, 783,6 сая төгрөгийн татаасыг ИНЕГ-ын төсөвт тусган санхүүжүүлсэн.

“Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийн төслийг энэ оны 9 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр боловсруулсан бөгөөд 2018-2021 онд хэрэгжүүлэх уг хөтөлбөрийн хүрээнд 9 аймгийн 12 чиглэлд долоо хоногт 1-2 удаагийн давтамжтай 1924 удаагийн нислэг гүйцэтгэж, агаарын тээврийн үйлчилгээг тогтворжуулж, нийтдээ 10,8 тэрбум төгрөгийн нөхөн олговор олгож, 50 000 орчим иргэдэд үйлчилгээ үзүүлэхээр төсөөлөл гаргаад байна.

Баруун болон зүүн аймгийн алслагдсан бүс нутагт агаарын тээврийн үйлчилгээг тогтворжуулах бодлогын хүрээнд агаарын хөлгийн шатахууныг баруун, зүүн хилийн боомтоор импортлох боломж бүрдүүлэх замаар шатахууны тээвэрлэлтийн зардлыг багасгах, зорчигчийн тасалбарын үнэ тарифыг бууруулах чиглэлээр ажиллаж байна.

Орон нутгийн агаарын тээврийг тогтвортой хөгжүүлэхгүйгээр агаарын тээврийн либералчлалыг хэрэгжүүлэх боломжгүй юм. Бодлогын хувьд орон нутгийн нислэгийг тогтворжуулах, олон улсын нислэгийн зорчигчдыг орон нутагт тээвэрлэх, аялал жуулчлалын нислэгийг өргөжүүлэх зохицуулалт бүрдүүлэх зорилгоор 2-3 жилийн

хугацаанд татаасын бодлогоор дэмжиж, зах зээлийг тогтворжуулах шаардлагатай байгаа болно.

Үүнтэй холбогдуулан орон нутгийн нислэгт олгох татаасыг агаарын навигацийн үйлчилгээний орлогоос санхүүжүүлэх тогтолцоо бүрдүүлэхээр Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд нисэхийн үйлчилгээний сан байгуулах зохицуулалтыг тусгах, мөн орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ, зорчигч тээврийн үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зохицуулалтыг бүрдүүлэхээр холбогдох хуулийн төслийг УИХ-ын 2018 оны намрын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хийж байна.

***Асуулт 7. Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын 1.2.10 дахь хэсэгт заасан арга хэмжээний биелэлт***

“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 3.8-д “агаарын тээврийн зах зээлийг үе шаттай чөлөөлөх бэлтгэлийг хангах зорилгоор үндэсний агаарын тээвэрлэгчийн олон улсын үндсэн нислэгийн чиглэлд (Улаанбаатар – Сөүл - Улаанбаатар, Улаанбаатар – Бээжин - Улаанбаатар) хоёрдогч тээвэрлэгчийг оруулахгүй байх, бусад тээвэрлэгчийг олон улсын бусад шугамд, орон нутаг, бүс нутгийн шугамд хуваарилах зарчмаар агаарын тээврийн зах зээлийг эдийн засгийн хувьд зохицуулах чиглэл баримтална” гэж, 3.9-д “гадаад улсын үндсэн нислэгийн чиглэлээс Монгол Улс руу хуваарьт нислэг үйлдэх тээвэрлэгчийн тухайд “нэг шугам-нэг тээвэрлэгч” бодлого баримталж, үндэсний компанийн өрсөлдөх чадварыг сайжруулж, ижил тэнцүү орчинд өрсөлдөх боломжийг бүрдүүлнэ” гэж заасан нь уг бодлогын “үе шаттай либералчлах” зорилттой зөрчилдөж байгаа болно.

“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын агаарын харилцааны либералчлалын талаар тусгасан зорилт өнөөг хүртэл хэрэгжээгүй, тодорхой үр дүнд хүрээгүй гэж дүгнэж, эхний шатанд хоёр талын Агаарын харилцааны хэлэлцээрийн хүрээнд Хятад, Солонгосны зах зээлийг чөлөөлж, зах зээлийн багтаамж, зорчигч урсгалыг нэмэгдүүлэх бодлого баримтлаж байна. Үүнтэй холбогдуулан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын 3.8. болон 3.9. заалтыг өөрчлөх талаар Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлал, тогтоолын төслийг боловсруулан, Засгийн газрын 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлсэн, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх шатанд байна.

Монгол Улсын олон улсын нислэгийн үндсэн чиглэлүүд болох Сөүл, Бээжингээс гадна Хонг Конг, Токио, Москва, Берлин чиглэлийн зах зээлийг өргөжүүлэн тогтворжуулах, Астана, Истанбулын чиглэлд нислэг гүйцэтгэх, аяллын дугаар хуваан ашиглах зарчмаар нислэгийн сүлжээг нэмэгдүүлэх зэрэг ажлыг хэрэгжүүлэх шаардлагатай. Мөн хил орчмын хотууд хооронд нислэгийн цар хүрээг өргөжүүлж, аялал жуулчлалын нислэгийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлагатай байгаа ч татаас олгох санхүүгийн боломж бүрдүүлээгүй тул төдийлөн хэрэгжихгүй байна. Өлгий, Даланзадгад, Ховд, Мөрөн хотын нисэх буудлууд олон улсын статустай, олон улсын нислэг гүйцэтгэх боломжтой хэдий ч агаарын тээвэрлэгчдийн хүчин чадлаас шалтгаалж хэрэгжихгүй байгаа болно.

Либералчлалын гол үзүүлэлт болох олон улсын агаарын тээвэрлэлтийн эрхийг чөлөөтэй олгох, агаарын тээвэрлэгчийн томилгоог хязгаарлахгүй байх, нислэгийн багтаамж, давтамж, агаарын хөлгийн маяг зэрэгт аливаа хязгаарлалт тавихгүй байх



зарчмууд Монгол Улсын агаарын харилцаанд хэрэгжээгүй, хязгаарлалттай хэвээр бөгөөд хяналттай либералчлалаас либералчлалд шилжих үе шат наад зах нь 6-8 жил үргэлжлэхээр байна.

Агаарын тээврийн салбарт чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, бодлогод заасан үе шаттай либералчлалыг хэрэгжүүлэх зорилгоор 2018 оны 03 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулсан “Агаарын тээврийн либералчлал-Иргэний нисэхийн салбарын шинэчлэл” сэдэвт салбарын удирдах ажилтны зөвлөгөөнөөр хэлэлцүүлэг зохион байгуулж, тус зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийг 2018-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 105 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг хангаж байна.

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

**“Корэйн Эйр” компанийн Улаанбаатар-Сөүлийн чиглэлтэй ойролцоо зайд үйлдэж буй бусад чиглэлийн нислэгийн тарифын судалгаа**

“Корэан Эйр” компани нь Сөүл-Улаанбаатар нислэгийн чиглэлд 11 ангилал /P, F, J, C, D, Y, B, M, H, E, G/, Улаанбаатар-Сөүл нислэгийн чиглэлд 15 /P, F, J, C, D, I, Y, B, M, S, H, E, K, L, G/ төрлийн үйлчилгээний нөхцөл, цаг хугацаанаас хамаарсан ангилал бүхий тариф, нэгдүгээр зэрэглэл /P, F/, бизнес зэрэглэл /J, C, D, I/, энгийн зэрэглэл /Y, B, M, S, H, E, K, L/, групп аялалын зэрэглэл /G/-ийн тариф дараах байдалтай байна.

Агаарын зай (1226 миль)				Хүснэгт 1.	
Нислэгийн чиглэлд мөрдөх тариф /төгрөг/				Мөнгөний нэгж	
Сөүл-Улаанбаатар		Улаанбаатар-Сөүл		Солонгос /Вон/	АНУ /доллар/
P	4,721,600	P	5,094,960	2,080,000	2,130
F	4,155,008	F	4,616,560	1,830,400	1,930
J	3,639,264	J	3,659,760	1,603,200	1,530
C	3,308,298	C	3,109,600	1,457,400	1,300
D	2,977,559	D	2,822,560	1,311,700	1,180
Y	2,431,170	I	2,320,240	1,071,000	970
B	1,608,295	Y	2,033,200	708,500	850
M	1,425,787	B	1,435,200	628,100	600
		M	1,267,760		530
		S	1,196,000		500
H	1,339,300	H	1,148,160	590,000	480
E	1,248,500	E	1,028,560	550,000	430
		K	980,720		410
		L	908,960		380
G	1,289,133	G	956,800	567,900	400

*Эх сурвалж: “Корэан Эйр” компани*

Тайлбар: Тарифт бусад төлбөр хураамжууд багтсан болно. Улаанбаатар болон Сөүлээс эхлэлтэйгээр 2 талын тийзний үнийг оруулав. Тухайн өдрийн валютын ханшаас хамаарч өөрчлөгдөнө. /2018.06.21-ний өдрийн Монгол банкны ханшаар 1 вон=2.27 төгрөг, 1 ам.доллар=2,392 төгрөг гэж тооцов./

“Корэан Эйр” компанийн Сөүл-Улаанбаатар-Сөүл чиглэлтэй ойролцоо, ижил зайд нислэг үйлддэг хотуудын чиглэлд мөрдөгддөг үнэ тариф дараах байдалтай байна. Үүнд:

**1. Сөүл-Гуанжоу нислэгийн чиглэл.**

Агаарын зай (1269 миль)				Хүснэгт 2.	
Нислэгийн чиглэлд мөрдөх тариф /төгрөг/				Мөнгөний нэгж	
Сөүл-Гуанжоу		Гуанжоу-Сөүл		Солонгос /Вон/	БНХАУ /юань/
P	4,338,651	P	6,504,498	1,911,300	17,100
F	3,817,913	F	5,743,738	1,681,900	15,100
J	3,291,046	J	2,814,812	1,449,800	7,400
C	2,991,860	C	2,548,546	1,318,000	6,700
D	2,837,500	D	2,282,280	1,250,000	6,000
I	2,497,000	I	2,168,166	1,100,000	5,700
Y	2,363,978	Y	1,863,862	1,041,400	4,900
B	1,566,300	B	1,407,406	690,000	3,700
M	1,362,000	M	1,217,216	600,000	3,200

		S	1,027,026		2,700
H	1,225,800	H	874,874	540,000	2,300
E	1,135,000	E	760,760	500,000	2,000
		K	684,684		1,800
G	908,000	G	532,532	400,000	1,400

Эх сурвалж: "Корейн Эйр" компани

## 2. Сөүл-Гүйянг нислэгийн чиглэл

Агаарын зай (1401 миль)

Хүснэгт 3.

Нислэгийн чиглэлд мөрдөх тариф /төгрөг/		Мөнгөний нэгж			
	Сөүл-Гүйянг		Гүйянг-Сөүл	Солонгос /Вон/	БНХАУ /юань/
P	4,789,700	P	7,455,448	2,110,000	19,600
F	4,222,200	F	6,580,574	1,860,000	17,300
J	3,632,000	J	3,119,116	1,600,000	8,200
C	3,291,500	C	2,852,850	1,450,000	7,500
D	2,973,700	D	2,548,546	1,310,000	6,700
I	2,610,500	I	2,130,128	1,150,000	5,600
Y	2,610,500	Y	2,244,242	1,150,000	5,900
B	2,360,800	B	1,863,862	1,040,000	4,900
M	2,111,100	M	1,673,672	930,000	4,400
		S	1,331,330		3,500
H	1,384,700	H	1,065,064	610,000	2,800
E	1,293,900	E	950,950	570,000	2,500
		K	836,836		2,200
		L	760,760		2,000
G	1,203,100	G	646,646	530,000	1,700

Эх сурвалж: "Корейн Эйр" компани

## 3. Сөүл-Хонг Конг нислэгийн чиглэл

Агаарын зай (1295 миль)

Хүснэгт 4.

Нислэгийн чиглэлд мөрдөх тариф /төгрөг/		Мөнгөний нэгж			
	Сөүл-ХонгКонг		ХонгКонг-Сөүл	Солонгос /Вон/	ХонгКонг доллар
P	4,718,422	P	6,844,188	2,078,600	21,900
F	4,152,284	F	6,031,636	1,829,200	19,300
J	3,462,658	J	3,718,988	1,525,400	11,900
C	3,147,582	C	2,968,940	1,386,600	9,500
D	2,832,960	D	2,687,672	1,248,000	8,600
I	2,565,100	I	2,062,632	1,130,000	6,600
Y	2,144,242	Y	2,062,632	944,600	6,600
B	1,498,200	B	1,593,852	660,000	5,100
M	1,271,200	M	1,250,080	560,000	4,000
		S	1,156,324		3,700
H	1,135,000	H	1,062,568	500,000	3,400
E	998,800	E	968,812	440,000	3,100
		K	906,308		2,900
		L	562,536		2,600
G	817,200	G		360,000	

Эх сурвалж: "Корейн Эйр" компани

**MEMORANDUM OF UNDERSTANDING**  
**Between KOREAN AIR and MIAT MONGOLIAN AIRLINES**  
**Concerning**  
**Enhancing of Strategic Partnership on KAL-MIAT Cooperation**

The KOREAN AIR (KAL) and MIAT Mongolian Airlines (MIAT) hereafter referred to as "the Parties":

RECOGNIZING our shared interest in developing of MIAT-KAL partnership on safety and services of both parties;

RECOGNIZING our obligations to fulfill market demands in cooperation and competition, and fully exercise responsibilities given by the designations under the Air Services Agreement signed by respective Governments;

RECOGNIZING our shared interest in improving quality of services on KAL-MIAT code share services and the benefits of enhancing of dispatch reliabilities of MIAT flights performing the shared services;

RECOGNIZING our shared commitment to the development of the air transportation and its importance to economic and trade development between the Republic of Korea and Mongolia;

**NOW THEREFORE**, the Parties have reached the following understanding:

- KAL will exert its best efforts to provide technical assistance to MIAT to bring efficiency in operation, especially in areas such as safety, flight and ground operations, maintenance management and cost controlling processes;
- KAL will exert its best efforts to help MIAT to bring its service qualities to world level and harmonize service standards that are aimed to prepare MIAT in joining of strategic alliances (Sky Team);
- Cooperation under this Memorandum shall be implemented in full compliance with any applicable governmental rules, regulations, and laws including, but not limited to competition laws of both the Republic of Korea and Mongolia;
- Cooperation under this Memorandum shall commence upon signing, and may be revised at any time by the written consent of the Parties. Either Party may terminate this Memorandum upon written notification to the other Party.

To this end, this Memorandum of Understanding is signed in Mongolia in duplicate and prepared in English.

For Korean Air

By:



Chang-Hoon Chi  
President & C.O.O.

For MIAT Mongolian Airlines

By:



Tseyen-Oidov ORKHON  
President & C.E.O.

**“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ,  
“КОРЭЙН ЭЙР КОМПАНИ” ХООРОНДУЙ КАЛ-МИАТ ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ ТАЛААР  
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

“МИАТ” төрийн өмчит хувьцаат компани (МИАТ) болон “Корэйн Эйр” компани (КАЛ) хамтад нь “Талууд” гэх

Талууд, МИАТ-КАЛ хооронд аюулгүй ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах тал дээр хамтран ажиллах хүсэл эрмэлзлэлийг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ;

Талууд, хоёр улсын Засгийн газрын хооронд байгуулсан Агаарын харилцааны хэлэлцээрийн дагуу олгогдсон эрх, үүргээ хэрэгжүүлэх, зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах үүргээ хамтын ажиллагаа болон өрсөлдөөний зарчмаар хослуулан явуулах шаардлагыг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ;

Талууд, МИАТ-КАЛ компани хооронд код хамтран эзэмших гэрээний дагуу үзүүлж буй үйлчилгээний чанарыг сайжруулах, үүний дотор “МИАТ” нь нислэгийн цаг ашиглалтын найдвартай байдлыг хангах үүргийг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ;

Талууд, Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын эдийн засаг, худалдааг өргөжүүлэхэд агаарын тээврийн салбарын хөгжил чухал болохыг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ;

**ДООРХ ЗҮЙЛИЙГ ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ:**

- КАЛ нь МИАТ-ын аюулгүй ажиллагаа, нислэг, газрын үйл ажиллагаа, агаарын хөлгийн засвар үйлчилгээний газрын удирдлага, зардал хянах зэрэг компанийн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн техникийн туслалцааг үзүүлэх замаар үйл ажиллагааг сайжруулах талаар хүчин чармайлт гарган ажиллана;
- КАЛ нь МИАТ-ын үйлчилгээний чанарыг дэлхийн түвшинд хүргэх улмаар МИАТ компанийн үйлчилгээний стандартыг “Sky Team” холбоонд нэгдэн орох стратегийн зорилтын бэлтгэлийг хангах чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллана;
- Талууд энэхүү Санамж бичгийг хоёр орны Засгийн газраас баталсан холбогдох дүрэм, журам, хуулийг хүрээнд, Монгол Улс болон Бүгд Найрамдах Солонгос улсын шударга өрсөлдөөний талаарх хууль тогтоомжоор хязгаарлагдахгүйгээр хэрэгжүүлнэ;
- Талууд энэхүү Санамж бичигт гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох ба харилцан зөвшилцсөний дагуу нэмэлт өөрчлөлт оруулж болно. Санамж бичгийг аль нэг талын бичгээр ирүүлсэн хүсэлтээр цуцлаж болно.

Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичгийг англи хэл дээр хоёр хувь үйлдэгдэж, Улаанбаатар хотод гарын үсэг зурав.

**“КОРЭЙН ЭЙР” КОМПАНИЙГ  
ТӨЛӨӨЛЖ:**

**“МИАТ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

**ЧАНГ-ХУНГ ЧИ  
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН  
ЗАХИРАЛ**

**ЦЭЕН-ОЙДОВЫН ОРХОН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

Огноо: 2012.03.26-ны өдөр.

Огноо: 2012.03.26-ны өдөр.